

Монголын бодлогын инновацийн хүрээлэн

Монголын залуучууд ба дэлхий дахин 2024 он

*Олон нийтийн санаа бодлын
судалгааны дүн*

Импрессум

Эрхлэн гаргасан

Фридрих-Эбертийн-Сан
Ландмарк төв
Чингисийн өргөн чөлөө 13
14251 Улаанбаатар
info.mongolia@fes.de

Хариуцсан

Доктор Д.Бямбажав
Ө.Пүрэвсүрэн
Доктор Ж.Мэндээ
Ц.Ариунболд
Доктор Штефани Ханкэ

Холбоо барих

Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь салбар
info.mongolia@fes.de

Эх бэлтгэл

Ё.Батболд

Хавтасны зураг

Ё.Батболд

Хэвлэлийн газар

“Мөнхийн үсэг” ХХК

Энэхүү судалгааны агуулга, мэдээллийн үнэн зөв нь Фридрих-Эбертийн-Сан болон Монголын бодлогын инновацийн хүрээлэнгийн байр суурьтай нийцэж байх албагүй болно. Уг бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул тус сангаас бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр болон эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах, арилжааны зориулалтаар хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

2025 оны 4-р сар
© Friedrich-Ebert-Stiftung e.V.

ISBN 978-9919-9976-3-2



Монголын бодлогын инновацийн хүрээлэн

2025 оны 4-р сар

Монголын залуучууд ба дэлхий дахин 2024 он

*Олон нийтийн санаа бодлын
судалгааны дүн*

Агуулга

Оршил1

Залуучуудын олон улсын харилцаа, гадаад бодлогын талаарх ойлголт,
хандлагыг тодорхойлох судалгаа3

 Сонирхол, мэдлэг3

 Ирээдүйн тухай төсөөлөл8

 Монгол Улсын гадаад бодлого12

 Зөөлөн хүчний бодлого23

 Шашин шүтлэг27

Дүгнэлт29

Судалгааны хүн ам зүйн үзүүлэлт33

Оршил

Олон улсын байдал, гадаад бодлого, улс орнуудын талаарх залуучуудын төсөөлөл, үнэлэмж, тэдний санаа бодлыг тандсан анхны судалгааг өмнө нь бид 2021 онд гүйцэтгэж байсан. Харин энэ удаа залуучуудын төсөөлөл, үнэлэмж хандлага хэрхэн өөрчлөгдсөнийг тандах зорилгоор хоёр дахь судалгааг хийж, Та бүхэндээ судалгааныхаа үр дүнг танилцуулж байна. Ингэхдээ улс орнуудын гадаад бодлогод гарч буй томоохон өөрчлөлтүүд, манай улсын гадаад бодлогын хүрээнд анхаарал татсан зарим асуудлуудыг залуус хэрхэн сонирхдог болохыг тодруулахыг оролдсон билээ. Энэ удаагийн судалгаа нь Орос-Украины дайн үргэлжиж, Ковид-19 цар тахал нилээд намжсаны дараа хийгдснээрээ онцлогтой.

Монгол Улсын хоёр хөрш болон “гуравдагч хөрш”-ийн орнуудын талаарх нийт иргэдийн санаа бодлыг тандсан судалгаа байдаг боловч эдгээр нь нийгэм, эдийн засаг, улс төрийн өргөн хүрээг хамарсан учраас олон улсын харилцаа, гадаад бодлоготой холбоотой тодорхой асуудлуудын хүрээнд иргэдийн, тэр дундаа залуучуудын санаа бодлыг гүнзгийрүүлэн судлах боломжийг хязгаарлаж байсан. Харин бидний судалгаа нь дээр дан ганц залуучуудын олон улсын харилцаа, гадаад бодлогын асуудлаарх санал бодлыг ойлгон судлахыг эрмэлзсэн болно.

Гадаад бодлогын асуудлаарх аливаа шийдвэрийг гаргах, бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэхэд шийдвэр гаргагч, бодлого боловсруулагчдын санаа бодолд голлон тулгуурлахын зэрэгцээ энэ чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтэн, судлаач, шинжээчдийн байр суурийг тодорхой хэмжээнд харгалзан үздэг. Гэвч иргэд олон нийт, тэр дундаа улс орны ирээдүй болсон залуу үеийн дуу хоолойг сонсох, тэд олон улсын харилцаа, дэлхий дахины нөхцөл байдлыг хэрхэн үнэлж, дүгнэдэг, төр, засгийн зүгээс гадаад орнуудын талаар ямар бодлого явуулбал зохилтой талаар ямар байр суурьтай байдаг зэргийг нь төдийлөн авч үзэхгүй, орхигдуулдаг тал бий. Гэтэл аливаа ардчилсан улсын гадаад бодлогын шийдвэр гаргалтад дотоод нөхцөл байдал, ялангуяа иргэд, сонирхлын бүлгүүдийн оролцоо ихээхэн нөлөөтэй байдаг. Түүнчлэн, Монгол Улсын хэмжээнд залуучууд гадаад ертөнцийн талаарх мэдээллийг хаанаас, ямар байдлаар хүлээн авч байгааг, тэд гадаад улс орон, хэл, соёлыг хэрхэн үнэлж эрэмбэлдэгийг зохистой түүврийн хэмжээнд судалсан судалгаа төдийлөн хийгддэггүй.

Иймд 18-35 хүртэл насны залуусын олон улсын харилцааны талаарх ойлголт, үнэлэмж, мэдлэг, мэдээллийн түвшин, гадаад бодлогын асуудлаарх байр суурь, бусад улс орнуудын үнэлэмжийг тодруулах зорилгоор энэхүү судалгааг Монголын бодлогын инновацийн хүрээлэн ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр авч, судалгааны үр дүнг нэгтгэн гаргалаа. Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2024 оны 9-10 дугаар сард Улаанбаатар хот, Орхон аймаг (Эрдэнэт хот), Булган аймаг, Төв аймагт гүйцэтгэсэн бөгөөд санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон нийт 1200 залуучууд оролцлоо.


Залуучуудын олон улсын харилцаа, гадаад бодлогын талаарх ойлголт, хандлагыг тодорхойлох судалгаа

Сонирхол, мэдлэг

Судалгаанд хамрагдсан залуучуудын 21.6 хувь нь гадаад мэдээг идэвхтэй сонирхон үздэг бол 46.8 хувь буюу олонх нь дунд зэрэг, 24.1 хувь нь гадаад мэдээг бага үздэг гэж хариулжээ. Залуучууд олон улсад өрнөж буй үйл явдал, гадаад мэдээг тодорхой хэмжээнд сонирхон үздэг гэж байгаа ч өмнөх буюу 2021 оны судалгааны дүнтэй харьцуулахад залуучуудын гадаад мэдээ үзэх сонирхол бага зэрэг буурсан дүнтэй гарч байна (График 1).

Та гадаад мэдээг хэр их сонирхдог вэ?

График 1




Залуучуудын олонх буюу 56.3 хувь нь гадаад мэдээг монгол хэлээр, 43.7 хувь нь гадаад хэлээр хүлээн авдаг байна. Үүнээс англи хэлээр гадаад мэдээ авдаг залуучууд 36.2 хувийг эзэлж байгаа бол орос, хятад, солонгос, япон хэлээр гадаад мэдээ авдаг залуучууд үлдсэн 7 орчим

хувийг, эдгээрээс бусад хэлээр гадаад мэдээ авдаг залуучууд маш бага буюу 0.6 хувийг эзэлж байна (График 2). Энэ нь өмнөх судалгааны дүнтэй ойролцоо гарсан үзүүлэлт юм.

Та гадаад мэдээг гол төлөв ямар хэлээр авдаг вэ?


График 2



Залуучуудын гадаад мэдээний гол эх сурвалж нийгмийн сүлжээ, цахим орчин болох төлөвтэй байна. Энэ удаа судалгаанд хамрагдсан залуучуудын 48.1 хувь нь гадаад мэдээг нийгмийн сүлжээнээс, 22.1 хувь нь телевизээс авдаг гэж хариулжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад нийгмийн сүлжээнээс гадаад мэдээ авдаг залуучуудын тоо 8 орчим хувиар өссөн бол телевизээс мэдээлэл авдаг залуучууд 1.2 хувиар буурсан байна. Нийт судалгаанд оролцогчдын 67 хувь нь гадаад мэдээг нийгмийн сүлжээ, мэдээллийн сайт зэрэг цахим орчноос авч байна (График 3).

Та гадаад мэдээг гол төлөв ямар эх сурвалжаас авдаг вэ?


График 3



Монголын залуучууд дэлхий дахинд ядуурал, эдийн засгийн хөгжлийн асуудал хамгийн их тулгамдаж байна гэж үзэх хандлага хэвээр байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад цар тахлын асуудлыг чухалчлах хандлага буурч, дайнаас үүдэлтэй асуудал дэлхий дахинд хамгийн их тулгамдаж байна гэж үзэх хандлага нэмэгдсэн дүнтэй гарчээ. Үүнд Орос-Украины дайн гол нөлөө үзүүлсэн байх талтай (График 4).

Та дэлхий дахинд тулгамдаж буй хамгийн чухал асуудлыг сонгоно уу.

График 4



Залуучуудын дэлхийн зарим улс орнуудад хандах хандлага, түүнд гарч буй өөрчлөлтийг судалж үзэхэд ихэнх улс орнуудыг “маш эерэг” гэж үзэх хандлага буурч, “ерөнхийдөө эерэг” гэж үзэх хандлага өссөн дүнтэй гарчээ. Гэхдээ монголын залуучууд Солонгос, Япон улсыг “маш эерэг”, БНХАУ-ыг “маш сөрөг” гэж үзэх хандлагатай байна. Урт хугацаандаа БНХАУ-ын талаар эерэг хандлагатай залуучууд нэмэгдэх төлөвтэй байна (Хүснэгт 1).

Та дараах улсуудын талаар ямар ойлголттой байдаг вэ?


Хүснэгт 1

Улс	Маш эерэг		Ерөнхийдөө эерэг		Ерөнхийдөө сөрөг		Маш сөрөг		Мэдэхгүй	
	2021	2024	2021	2024	2021	2024	2021	2024	2021	2024
ОХУ	32.9	16.7	52.2	57.8	3.1	15.9	6.1	2.6	5.7	6.9
БНХАУ	11.3	7.0	38.0	41.6	13.7	32.4	30.4	12.5	6.6	6.5
АНУ	29.2	18.5	52.8	56.2	2.9	13.4	6.5	2.2	8.6	9.7
ХБНГУ	27.6	17.1	45.5	52.2	5.8	11.0	2.4	2.8	18.7	16.9
Япон	42.6	25.5	40.8	51.9	2.4	9.9	5.0	1.6	9.0	11.2
БНСУ	38.5	26.9	46.9	54.3	1.7	8.7	4.6	2.3	8.3	7.7

Монголын залуучууд дэлхийн улс орнуудын удирдагчдаас хоёр хөршийн төрийн тэргүүн болох Владимир Путин, Си Зиньпин нарыг улс орноо хамгийн сайн удирдаж байна гэж үзэж байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад ОХУ-ын ерөнхийлөгч В.Путиныг сонгосон залуучууд 12.6 хувиар буурч, БНХАУ-ын дарга Си Зиньпинийг сонгосон залуучууд 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна (График 5).

Таны бодлоор дараах гадаад орны удирдагчдаас хэн нь улс орноо сайн удирдаж байна вэ?


График 5



Олон улсын байгууллагуудын талаарх ойлголт, төсөөлөлд тодорхой өөрчлөлт гараагүй, өмнөх судалгааны дүнтэй ойролцоо түвшинд байна. Олон улсын байгууллагуудыг “Мэднэ” гэж хариулсан хувилбарыг өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бага зэрэг буурсан дүнтэй гарчээ (График 6).

Та дараах олон улсын байгууллагуудыг мэдэх үү? (Мэднэ)

График 6




Ирээдүйн тухай төсөөлөл

Дэлхийн их гүрнүүд болох АНУ, БНХАУ-ын ирээдүйн талаар залуучуудын төсөөллийг тандаж үзэхэд өмнөх судалгааны дүнтэй ойролцоо гарсан байна.

БНХАУ-ыг ирээдүйд эдийн засгаараа тэргүүлэгч улс болно гэж 42.4 хувь, энх тайвныг эрхэмлэгч улс болно гэж 7.9 хувь, дэлхийн асуудлыг шийдвэрлэгч улс болно гэж 16.7 хувь нь тус тус хариулсан бол 21 хувь нь эзлэн түрэмгийлэгч улс болно гэж үзэж байна (График 7).

Та ирээдүйд Хятадыг ямар улс болно гэж бодож байна вэ?


График 7



Ирээдүйд олон улсын харилцаанд үзүүлэх АНУ-ын нөлөө нэмэгдэнэ гэж хариулсан залуучууд өмнөх судалгааны дүнгээс 1.5 хувиар буурсан бол АНУ нөлөөгөө энэ хэвээр хадгална гэж үзэж буй залуучууд 1.1 хувиар өссөн байна. Харин АНУ-ын нөлөө буурна гэж хариулсан залуучууд 5 орчим хувиар буурчээ. Эндээс харахад монголын залуучууд цаашид олон улсын харилцаанд БНХАУ-ын нөлөө нэмэгдэж, АНУ-ын нөлөө тодорхой хэмжээнд буурна гэж үзэж буй байдал ажиглагдаж байна (График 8).

Та ирээдүйн олон улсын харилцаанд АНУ-ын үзүүлэх нөлөөг хэрхэн харж байна вэ?


График 8



Энэ утгаараа залуучууд ирээдүйд Хятад-Америкийн өрсөлдөөн, хурцадмал байдал нэмэгдэнэ гэж үзэх хандлагатай байна. Судалгаанд хамрагдсан залуучуудын 22.2 хувь нь ирээдүйд Хятад-Америкийн өрсөлдөөн, хурцадмал байдал маш их нэмэгдэнэ гэж хариулсан бол 40.4 хувь нь бага зэрэг нэмэгдэнэ гэж хариулжээ. Эдгээр хариултын нийлбэр 62.6 хувийг эзэлж байна. Харин Хятад-Америкийн өрсөлдөөн, хурцадмал байдал буурна гэж 8.1 орчим хувь нь хариулжээ (График 9).

Ирээдүйд Хятад-Америкийн хоорондын өрсөлдөөн, хурцадмал байдал нэмэгдэнэ гэдэгт та итгэж байна уу?

График 9



Монгол Улсын ирээдүйн хөгжилд хоёр хөрш орон хамгийн их нөлөөтэй гэж үзэх хандлагатай байна. Судалгаанд оролцогч залуучуудын тал орчим хувь нь ОХУ, БНХАУ нь Монгол Улсын ирээдүйд маш их нөлөөтэй гэж хариулжээ. Энэ хувь хэмжээ 2021 оны судалгааны дүнтэй харьцуулахад 5 орчим хувиар буурсан үзүүлэлт юм. Залуучууд Энэтхэг улсыг Монгол Улсын ирээдүйд төдийлөн нөлөөтэй гэж үзэхгүй байна. АНУ, ХБНГУ, Япон улсууд нөлөө багатай гэж үздэг залуучууд буурч, дунд зэргийн нөлөөтэй гэж үздэг залуучууд нэмэгдсэн байна (Хүснэгт 2).

Таны бодлоор Монгол Улсын ирээдүйн хөгжилд дараах улсууд хэр их нөлөөтэй вэ?

Хүснэгт 2

Улсууд	Маш их		Их		Дунд		Бага		Мэдэхгүй	
	2021	2024	2021	2024	2021	2024	2021	2024	2021	2024
ОХУ	56.2	50.3	28.5	34.2	9.9	10.3	1.8	0.9	3.7	4.3
БНХАУ	53.3	48.5	29.0	33.0	9.8	10.9	3.2	2.7	4.7	4.9
Япон	19.2	18.4	36.2	35.9	29.5	31.3	6.2	4.3	8.8	10.2
АНУ	16.4	16.4	31.0	31.6	30.7	35.1	11.0	6.1	10.9	10.7
ХБНГУ	8.3	6.2	20.2	20.3	32.1	42.4	18.9	13.6	20.5	17.5
Энэтхэг	-	4.3	-	16.2	-	37.8	-	20.7	-	21.0
БНСУ	-	17.1	-	32.0	-	31.7	-	7.3	-	11.9

Одоогийн байдлаар Монгол Улсын хувьд гадаад улсаас эдийн засгийн хараат болох аюул хамгийн их гэж судалгаанд оролцогч залуучууд үзэж байна. Энэ хувь хэмжээ жил ирэх тусам нэмэгдэх төлөвтэй. Мөн гадны соёл, шашны нөлөө, кибер халдлага, цэргийн хүчээр эзлэн түрэмгийлэх аюул зэрэг асуудлууд Монгол Улсын аюулгүй байдалд сөрөг нөлөө учруулж болзошгүй гэж үзжээ. Өмнөх судалгаа нь ковидын цар тахлын үеэр хийгдэж байсан учраас цар тахал, халдварт өвчнийг тулгамдсан аюул гэж үзэж байсан бол энэ удаагийн судалгаагаар төдийлөн тулгамдсан аюул гэж үзэхгүй байна (График 10).

**Өнөөгийн байдлаар гадаад улсаас Монгол Улсад
учруулж болох хамгийн том аюул занал юу вэ?**

График 10



Залуусын төсөөллөөр Монгол Улсын аюулгүй байдалд тулгарч буй сорилт, бэрхшээл ойрын арван жилдээ үргэлжлэх төлөвтэй. Эдийн засгийн хараат байдалд орохын зэрэгцээ гадны соёл, шашны нөлөөнд орох магадлал өндөр гэж үзэж байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтийг 10 гаруй хувь нь чухалчилж байна (График 11).

**Ирэх 10 жилийн хугацаанд гадаад улсаас Монгол
улсад учруулж болох хамгийн том аюул занал юу вэ?**

График 11




Монгол Улсын гадаад бодлого

Монгол Улс газар зүйн байрлал, геополитикийн орчны хувьд Зүүн хойд Азийн улс уу? Төв Азийн улс уу? Энэ талаар залуучууд ямар бодолтой байгааг судалж үзэхэд дийлэнх нь Төв Азийн улс гэж үзэж байна (График 12). Судалгааны мэдээлэл цуглуулах явцад залуус гол төлөв газар зүйн байрлал талаас нь харж, сонгож буй нь ажиглагдаж байсан. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад бүс нутгийн талаарх энэхүү ойлголт, төсөөлөлд томоохон өөрчлөлт гараагүй байна.

Таны бодлоор Монгол Улс доорх бүс нутгийн алинд нь хамаарах вэ?

График 12




Залуучууд Монгол Улсын хувьд хоёр хөрш орныг хамгийн ойрын түнш гэж үзэх хандлагатай байна. Гуравдагч хөршийн орнуудаас Солонгос, Япон улсыг маш ойрын түнш гэж үзэх залуучууд олон байна. Харин АНУ, ХБНГУ, Энэтхэг улсыг нэг их ойрын түнш биш гэж залуучууд үзэж байна (Хүснэгт 3). Залуучуудын ойрын түнш гэдгийг сонгоход геополитикийн орчноос гадна, тухайн улсад монголчууд хэр их ажиллаж, амьдарч байна вэ? гэдэг асуудал нөлөөлсөн байх талтай. Өөрөөр хэлбэл монголчууд олноор ажиллаж амьдардаг улсын талаар гэр бүл, найз нөхөд, нийгмийн сүлжээнээс эерэг мэдээлэл авдаг байх магадлалтай.

Улсууд	Маш ойр		Ерөнхийдөө ойр		Нэг их ойр биш		Огт ойр биш		Мэдэхгүй	
ОХУ	66.1	66.5	27.6	27.9	3.5	2.9	0.7	0.3	2.1	2.5
БНХАУ	60.9	61.9	30.1	28.9	5.5	5.5	0.9	0.5	2.6	3.2
Япон	8.4	9.6	43.2	53.2	34.0	27.5	7.3	1.6	7.1	8.1
АНУ	4.0	5.7	24.9	33.8	40.3	45.5	20.5	6.1	10.3	9.0
ХБНГУ	3.0	3.1	13.5	23.2	31.8	47.5	30.1	10.7	21.6	15.5
Энэтхэг	-	2.5	-	15.6	-	45.1	-	16.8	-	20.0
БНСУ	-	12.6	-	42.8	-	29.4	-	5.2	-	10.1

Монгол Улсын гадаад бодлогод чухал нөлөө бүхий хоёр хөрш орны талаар залуучууд эерэг, сөрөг ямар хандлагатай байгааг тандаж үзлээ. БНХАУ-ын тухайд эерэг хандлага буюу хуучны түнш улс, эдийн засгийн боломж, хөгжлийн түнш улс гэсэн хариултуудын нийлбэр 50 орчим хувийг эзэлж байна. Мөн сөрөг хандлага буюу дээрэнгүй их гүрэн, аюул занал, болгоомжлох ёстой улс гэсэн хариултуудын нийлбэр 50 хувийг эзэлж байна. Дээрэнгүй их гүрэн, аюул занал гэж үздэг залуучуудын эзлэх хувь буурсан бол болгоомжлох ёстой улс гэж хариулсан залуучуудын эзлэх хувь 7.2 хувиар өссөн байна (График 13).

Та БНХАУ-ыг Монгол улсын хувьд ямар байдлаар хардаг вэ?


График 13



ОХУ-ын тухайд эерэг хариултын нийлбэр 72.7 хувь, сөрөг хариултын нийлбэр 27.3 хувьтай байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад эерэг хариултын нийлбэр 2.6 хувиар буурсан бол сөрөг хариултын нийлбэр 2.5 хувиар өссөн байна. Социалист нийгмийн үед ЗХУ-ыг монголчууд “Орос ах” нар хэмээн нэршиж заншсан байдаг. Энэ ойлголт, хандлага одоо хэр түвшинд байгааг судалж үзэхэд 34.5 хувь нь тус хариултыг сонгож байна. Өмнөх судалгааны “Хуучны түнш” гэсэн хариулттай дүйцүүлэн харьцуулахад 8.2 хувиар илүү байна. ОХУ-ыг эдийн засгийн боломж, хөгжлийн загвар улс гэж эерэг талаас нь хардаг залуучууд буурч, дээрэнгүй их гүрэн, болгоомжлох ёстой улс гэж сөрөг талаас нь хардаг залуучууд нэмэгдсэн дүнтэй гарчээ (График 14).

Та ОХУ-ыг Монгол Улсын хувьд ямар байдлаар хардаг вэ?

График 14



Монгол Улсын иргэд хилийн чанадад олноор ажиллаж, амьдрах болсонтой холбоотой тэдгээр иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудлыг ихэнх залуучууд гадаад бодлогын чухал асуудал гэж үзжээ. Өмнөх судалгааны дүнд гадаад дахь монгол иргэдийн эрх ашгийг хамгаалах асуудал гуравдугаарт эрэмбэлэгдэж байсан бол энэ удаа нэгдүгээрт эрэмбэлэгдэж байна. Түүнчлэн гадаадын хөрөнгө оруулалтыг татах, гадаад худалдааг төрөлжүүлэх асуудлыг 37 орчим хувь нь чухалчилж байна. Бусад хариултад томоохон өөрчлөлт гараагүй байна (График 15).

Монгол Улсын гадаад бодлогын хамгийн чухал гурван асуудал юу вэ?


График 15



Харин Монгол Улс олон улсын энхийг сахиулах ажиллагаа дахь оролцоогоо нэмэгдүүлэх шаардлагатай гэж 79.7 хувь нь үзсэн бөгөөд өмнөх судалгааны дүнгээс 3 орчим хувиар өссөн үзүүлэлтэй байна (График 16).

Таны бодлоор Монгол Улс олон улсын энхийг сахиулах ажиллагаан дахь оролцоогоо нэмэгдүүлэх хэрэгтэй юу?


График 16



Иргэд, олон нийтийн дунд Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элсэх тухай асуудлаар ихээхэн маргаан өрнөдөг. Энэ асуудлаар залуучуудын байр суурьд томоохон өөрчлөлт гараагүй боловч гишүүнээр элсэх шаардлагагүй гэж үздэг залуучууд 2.7 хувиар өссөн байна (График 17).

Монгол Улс Шанхайн хамтын ажиллагааны байгууллагад гишүүнээр элсэх нь зөв үү?


График 17



Монгол Улсын эдийн засаг гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжаас ихээхэн хамааралтай. Залуучуудын хувьд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкнаас зээл, тусламж авбал аюулгүй байдлын хувьд эрсдэл багатай гэж үзэх хандлагатай байна. Түүнчлэн ОХУ-аас зээл, тусламж авах нь аюулгүй байдлын хувьд зөв гэж үзэх залуучуудын тоо харьцангуй их нэмэгдсэн бол БНХАУ-аас зээл тусламж авах нь зүйтэй гэж үздэг залуучуудын тоо буурсан дүнтэй гарчээ (График 18).

Монгол Улс хэнээс түлхүү зээл, тусламж авбал аюулгүй байдлын хувьд зүйтэй вэ?


График 18



Гаднаас зээл тусламж авахад аюулгүй байдлын хувьд хөрш орнуудаас гадна Япон улсаас зээл авах нь зүйтэй гэж цөөнгүй залуучууд үздэг. Түүнчлэн сүүлийн жилүүдэд залуучуудын БНСУ, Япон улсад хандах эерэг хандлага нэмэгдэх болсон. Энэ утгаараа Монгол Улс Япон улстай байгуулсан чөлөөт худалдааны гэрээ хоёр улсын харилцаанд чухал үүрэгтэй. Харин судалгаанд оролцогч залуучуудын 77.5 хувь буюу дийлэнх нь энэ гэрээний талаар мэдэхгүй байна (График 19).

Монгол Улс Япон улстай чөлөөт худалдааны гэрээ байгуулсан талаар та мэдэх үү?


График 19



Монгол Улс Сэлэнгэ мөрний цутгал дээр Эгийн голын усан цахилгаан станц барих нь Байгаль нуурын эко системд сөрөг нөлөөтэй эсэх асуудлаар олон нийтийн дунд багагүй маргаан өрнөдөг. Ялангуяа нийгмийн сүлжээнд иргэд Эгийн голын усан цахилгаан станцыг ОХУ-аас зориуд бариулахгүй байх бодлоготой гэдэг асуудлыг хөнддөг. Тэгвэл судалгаанд оролцсон залуучуудын 32 хувь нь усан цахилгаан станц бариулахыг ОХУ-аас эсэргүүцдэг гэж үзэж байна. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад энэ хувь хэмжээ 2.4 хувиар өссөн бол энэ байр суурьтай санал нийлдэггүй залуучуудын тоо 2.1 хувиар буурсан байна. Өөрөөр хэлбэл Эгийн голын усан цахилгаан станцыг барихыг ОХУ-аас эсэргүүцдэг гэж үзэх залуучуудын тоо нэмэгдэх хандлагатай байна (График 20).

Байгаль нуурт цутгадаг Монгол Улсын гол мөрөн дээр усан цахилгаан станц барихыг ОХУ эсэргүүцдэг.


График 20



Монгол Улсын гадаад бодлогын хүрээнд төр, засгийн тэргүүн холбогдох албан тушаалтнууд хилийн чанадад айлчлал хийдэг. Энэхүү айлчлалын мөрөөр хийгдэж буй ажил, гадаад айлчлалын талаар залуучуудын сэтгэл ханамжийг тандаж үзэхэд бо орчим хувь нь зарим талаар үр дүнтэй гэж хариулжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад маш үр дүнтэй гэж хариулсан залуучууд 4 орчим хувиар өссөн байна (График 21).

Та Монгол Улсын төр, засгийн тэргүүн нарын хийдэг гадаад айлчлалыг хэрхэн үнэлэх вэ?

График 21



Монгол Улс олон улсын тавцанд өөрийгөө таниулахад үндэсний түүх, соёл, онгон дагшин байгаль, нүүдлийн соёл иргэншлийг сурталчлан таниулах шаардлагатай гэж судалгаанд оролцогч залуучууд үзэж байна. Энэ удаагийн судалгаагаар хариултын хувилбарт нүүдлийн соёл иргэншлийг нэмэлтээр оруулсан бөгөөд залуучуудын 15.7 хувь нь тус хариултыг сонгожээ (График 22).

Таны бодлоор Монгол улс олон улсын тавцанд өөрийгөө таниулахад аль нь илүү чухал ач холбогдолтой вэ?


График 22



Монгол Улсын засгийн газраас 2023-2024 оныг Монголд зочлох жил болгон зарласан. Энэ хөтөлбөрийг залуучуудын 37 хувь нь жуулчдыг татах үр дүнтэй хөтөлбөр гэж харж байгаа бол 22 хувь нь хэдийгээр ийм хөтөлбөр гарсан ч дорвитой үр дүн гарахгүй гэж үзэж байна. Харин 40 гаруй хувь энэ хөтөлбөрийн талаар мэдээлэлгүй байна (График 23).

Засгийн газраас хэрэгжүүлж буй Go Mongolia хөтөлбөрийг юу гэж бодож байна вэ?

График 23



Цаашид Монгол Улс нүүдлийн соёл иргэншилд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдаар дамжуулан эх орноо сурталчлан таниулах боломж байна. Монголчууд гадаадын жуулчдыг эдийн засагт хөрөнгө оруулалт хийж, эх орноо сурталчлан таниулах боломж гэж эерэг талаас нь гол төлөв харж байна. Хэдийгээр 78.3 хувь нь гадаадын жуулчдыг эерэг талаас нь харж буй боловч 12.3 хувь нь сөрөг талаас харж байна (График 24).

Та Монгол Улсад ирж буй гадаадын жуулчдыг та юу гэж боддог вэ?


График 24



Монгол Улсын стратегийн бүтээн байгуулалт болох нийтийн тээврийн метрог аль улсын компани барих нь чухал асуудал. Судалгаанд оролцогч залуучуудын 32.8 хувь нь Япон, 18.4 хувь нь Бүгд найрамдах Солонгос Улс Улаанбаатар хотод метро барих нь оновчтой гэж үзэж байна. Эдгээр хариултын нийлбэр судалгаанд оролцогчдын талаас илүү хувийг эзэлж байна. Түүнчлэн 13.2 хувь нь метро барихад аль улс байх нь чухал биш гэж хариулсан дүн гарчээ (График 25).

Улаанбаатар хотод аль улсын компани метро баривал оновчтой вэ?


График 25



Судалгаанд оролцогч залуучуудын 44.8 хувь нь ОХУ-Украины хооронд өрнөж буй дайн Монгол Улсад сөрөг нөлөө үзүүлж байна гэж үзсэн бол 4 хувь нь эерэг нөлөө үзүүлж байна гэж үзжээ. Харин судалгаад оролцогчдын талаас илүү хувь нь энэ асуудлыг мэдэхгүй гэсэн хариулт сонгосон байна (График 26).

Орос-Украины хооронд өрнөж буй дайн Монгол Улсад ямар нөлөө үзүүлж байна вэ?


График 26



Ихэнх залуучууд Орос-Украины хооронд үүссэн нөхцөл байдлын асуудлаар Монгол Улс төвийг сахих ёстой гэсэн байр суурь илэрхийлж байна. Үүнийг сүүлийн үеийн Барометрын судалгаа (НБ)-ны дүнтэй харьцуулахад Украиныг дэмжих ёстой гэсэн байр суурийг залуучууд гол төлөв дэмжих хандлагатай байна. Бүх насны иргэдийг хамруулсан судалгаагаар Украиныг дэмжих ёстой гэсэн байр суурь 2.6-5.3 хувьтай байсан бол залуучуудын судалгаагаар 7.4 хувьтай гарч байна (График 27).

Орос-Украины хооронд үүссэн нөхцөл байдлын асуудлаар Монгол Улс ямар байр суурь баримтлах ёстой гэж Та бодож байна вэ?

График 27




Зөөлөн хүчний бодлого

Монгол Улс дэлхийн олон улс орны зөөлөн хүчний бодлогын нөлөөнд өртөж ирсэн. Зарим улс өөрсдийн гадаад бодлогын хүрээнд тодорхой хөрөнгө зарцуулж, зорилтот төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн бол зарим улсад монголчууд өөрсдөө зорчиж, тухайн улсын соёл, үнэт зүйл, амьдралын хэв маягийг даган дуурайх хандлагатай болсон. Өөрөөр хэлбэл залуучуудын гадаад дуу хөгжим сонсох, кино урлагийн бүтээл үзэх, хэл, соёл иргэншлийг даган дуурайх, гадаадад сурах, ажиллах, амьдрах хүсэл эрмэлзлээс тодорхой болсон. Хэрэв залуучуудад боломж олдвол 17.7 хувь нь Америкт, 16.5 хувь нь Солонгост, 12.4 хувь нь Австралид, 12.2 хувь нь Германд суралцах хүсэлтэй гэдгээ илэрхийлжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад Солонгос, Австрали, Герман, Франц улсад суралцах сонирхолтой залуучууд нэмэгдсэн байна (График 28).

Та гадаад улсад суралцах боломжтой болбол эдгээр улсаас алийг нь сонгох вэ?


График 28



Монголын залуучууд англи хэлээс гадна солонгос, хятад хэлийг сурах сонирхолтой байна (График 29). Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад солонгос, англи хэл сурах сонирхолтой залуучууд нэмэгдсэн дүнтэй гарчээ.

Та аль нэг гадаад хэлийг суралцах боломжтой тохиолдолд доорхоос алийг нь сонгох вэ?


График 29



Монголчуудын идээ ундааны соёл нь нүүдэлчин амьдрал, дөрвөн улирлын хэв маягт тохирсон өөрийн гэсэн өвөрмөц онцлог арвин баялаг түүхтэй. Сүүлийн жилүүдэд хот суурин газрууд дахь гадаад хоолны ресторан, үйлчилгээний соёлыг дагаж залуучууд төрсөн өдөр, уулзалт, аливаа баяр ёслолыг гадаад ресторанд тэмдэглэх үзэгдэл түгээмэл болсон. Үүнийг дагаад зарим улсын хооллох соёл манай улсад нэвтэрч эхэлсэн. Судалгаанд оролцсон залуучуудын 56.2 хувь нь солонгос хоол идэх дуртай гэж хариулсан бол 10.2 хувь нь хятад хоол идэх дуртай гэж хариулжээ. Өмнөх судалгаатай харьцуулахад солонгос хоолонд дуртай залуучуудын тоо эрс нэмэгдсэн байна. Хятад, солонгос хоолонд дуртай залуучууд 66.4 хувийг эзэлж байна (График 30).

Гадаад хоолноос таны хамгийн дуртай нь аль нь вэ?


График 30



Зөөлөн хүчний бодлогын нөлөөнд өртөж байгаа илэрхийлэл нь тухайн улсын соёл урлаг, кино телевизийн бүтээлийг шимтэн сонирхох, даган дуурайх үзэгдэл юм. Залуучуудын олонх буюу 39.7 хувь нь солонгос кино үзэх дуртай гэж хариулжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад Англи-Америк кино үздэг залуучууд буурч, солонгос кино үздэг залуучууд нэмэгдсэн байна (График 31).

Та дараахаас аль улсын кино, телевизийн бүтээлийг гол төлөв үзэх дуртай вэ?


График 31



Кино, телевизийн бүтээлээс гадна ямар дуу хөгжим сонсож байгаагаар нь залуучуудын оюун санаа, хүсэл эрмэлзэл харагдана. Монголын залуучуудын 53.2 хувь Англи-Америк дуу сонсох дуртай бол 19.1 хувь нь солонгос дуу сонсох дуртай гэж хариулжээ. Өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад Англи-Америк дуу сонсдог залуучуудын тоо нэмэгдсэн байна (График 32).

Та дараахаас аль улсын дуу, хөгжмийн бүтээлийг гол төлөв сонсох дуртай вэ?


График 32



Улс орны нийгэм эдийн засгийн нөхцөл байдал, нийгмийн тулгамдсан асуудлуудаас үүдэн залуучууд гадаад руу гарах, буцаж ирэхгүй байх хандлагатай болсон. Судалгаанд оролцсон залуучуудын 68.7 хувь нь хэрэв гадаад улсад ажиллаж амьдрах боломж олдовол Монгол Улсаас явна гэж хариулжээ. Харин 16.3 хувь нь явахгүй, 15 хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг сонгожээ (График 33). Өөрөөр хэлбэл залуучуудын виз гарсан тохиолдолд дийлэнх нь эх орноосоо явах төлөвтэй байна.

Хэрэв танд гадаад улсад ажиллаж амьдрах боломж олдовол Та Монгол Улсаас явах уу?


График 33



Эдгээр залуучууд гол төлөв Америк эсвэл Солонгос, Япон улс руу гарах хүсэлтэй байна. Түүнчлэн ХБНГУ, БНХАУ, ОХУ-д ажиллаж амьдрах хүсэлтэй залуучууд харьцангуй их байна (График 34). Бусад улс гэдэгт Австрали, Канад зэрэг улсыг гол төлөв сонгосон байв.

Хэрэв та гадаад улсад ажиллаж амьдрах боломж олдовол аль улс руу явахыг хүсэж байна вэ?


График 34



Гадаадад ажиллаж амьдрахаас илүүтэй аялах сонирхолтой ямар улс байгааг судалж үзэхэд мөн АНУ, Япон, Солонгос улс тэргүүлж байна. БНХАУ, ХБНГУ, БНТУ улс дараагийн дугаарт эрэмбэлэгдэж байна. ОХУ-ыг хамгийн бага буюу 6.3 хувь нь сонгожээ (График 35).

Хэрэв танд гадаад улс руу аялах боломж олдвол аль улсад аялах вэ?

График 35



Шашин шүтлэг


Монгол Улсын нийт хүн амын 59.4 хувь нь шашин шүтдэг, 40.6 хувь нь шашин шүтдэггүй гэсэн статистик мэдээлэл байдаг. Харин судалгаанд оролцогч залуучуудын 49 хувь нь шашин шүтдэг, 51 хувь нь шашин шүтдэггүй гэж хариулжээ (График 36). Энэхүү тоон мэдээллийг харьцуулж харахад залуучууд шашин шүтдэггүй байх тохиолдол харицангуй их байна.

Та шашин шүтдэг үү?

График 36



Шашин шүтдэг залуучуудын 58.8 хувь нь буддын, 19.5 хувь нь бөө мөргөлийн, 8.5 хувь нь христийн, 3.8 хувь нь мусульман, 9.4 хувь нь бусад шашин шүтдэг гэж хариулжээ (График 37). Бөө мөргөлийн шашин шүтдэг залуучууд буддын болон бөө мөргөлийн шашныг хослуулан шүтэх тохиолдол их гарч байв.




Хэдийгээр залуучуудын 49 хувь нь ямар нэг шашин шүтдэг гэх боловч өөрийн шүтдэг шашныхаа үндсэн судар, номлол, сургаалыг сайн мэдэхгүй, сүм хийдэд төдийлөн очдоггүй, өөрөөр хэлбэл хэлбэр төдий шүтдэг байдал ажиглагдаж байна. Судалгаанд оролцогч залуучуудын 47.3 хувь нь сүм хийдэд огт очдоггүй гэж хариулсан бол 38.9 хувь нь жилдээ ганц нэг удаа сүм хийдэд очдог гэж хариулжээ. Өөрөөр хэлбэл 86.2 хувь нь сүм хийдэд төдийлөн очдоггүй, шашныг гүн гүнзгий шүтдэггүй гэж дүгнэж болохоор байна (График 38).



Түүнчлэн Монгол Улсад шашны эрх чөлөөг хүндэтгэдэг учраас гаднын шашны байгууллагуудын үйл ажиллагааг хатуу хянах шаардлагагүй гэсэн байр суурьтай санал нийлж байгаа эсэхийг судалж үзэхэд 40.1 хувь нь санал нийлэхгүй гэсэн хариултыг сонгожээ (График 39). Өөрөөр хэлбэл тодорхой хэмжээнд шашны байгууллагуудын үйл ажиллагааг хянаж байх ёстой гэсэн байр суурь илэрхийлж байна.

Монгол Улсад шашны эрх чөлөөг хүндэтгэдэг учраас гадаадын шашны байгууллагуудын үйл ажиллагааг хатуу хянах шаардлагагүй. Та үүнтэй санал нийлэх үү?

График 39



Дүгнэлт

Олон улсын харилцаа, гадаад үйл явдлын талаарх ойлголт, хандлага

- Дэлхий дахинд өрнөж буй үйл явдлыг залуучууд тодорхой түвшинд сонирхон судалж, өөрсдийн байр сууриа илэрхийлсээр байна. Тухайлбал дэлхий дахинд тулгамдаж буй уламжлалт асуудлуудаас гадна дайнаас үүдэлтэй сөрөг үр дагавар олон байгааг энэ удаагийн судалгаанд оролцогчид онцолж байна. Ялангуяа Орос-Украины дайн Монгол Улсад сөрөг нөлөө учруулж байна гэж залуучуудын 44.8 хувь нь хариулсан байна. Энэхүү дайны асуудлаар олон улсад Монгол Улс төвийг сахих ёстой гэсэн байр суурийг дийлэнх залуучууд илэрхийлж байна. Бүх насны иргэдээс авсан судалгааны дүнтэй харьцуулахад залуучууд Украиныг дэмжих хандлага арай илүү байгаа нь ажиглагдаж байна.
- Залуучуудын улс орнуудад хандах хандлага, түүнд гарч буй

өөрчлөлтийг судалж үзэхэд хоёр хөрш болох ОХУ, БНХАУ болон Солонгос, Япон улсад хандах хандлага бусад орнуудаас өөр байна. Монгол Улсын газар зүйн байршлын онцлог, геополитикийн орчин гэдэг утгаараа ОХУ, БНХАУ-ыг улс орны ирээдүйн хөгжил, гадаад бодлогод чухал нөлөөтэй болохыг онцолж байна. Гуравдагч хөршийн орнуудаас Солонгос, Япон улсыг залуучууд харьцангуй эергээр харж байна. Бусад улс орнуудыг төдийлөн ойрын түнш гэж үзэхгүй байна.

- Ирээдүйд БНХАУ дэлхий дахинд эдийн засгаараа тэргүүлэгч улс болохын зэрэгцээ олон улсын харилцаан дахь нөлөөгөө бэхжүүлэх, Америк-Хятадын хоорондын өрсөлдөөн, хурцадмал байдал нэмэгдэнэ гэж үзэх хандлагатай байна. Харин АНУ-ын тухайд одоогийн нөлөөгөө энэ хэвээр хадгална гэж 31.5 хувь нь хариулсан бол нөлөөгөө улам бүр бэхжүүлнэ гэж 36.4 хувь нь хариулжээ.

Монгол Улсын аюулгүй байдал, гадаад бодлого

- Өнөөгийн байдлаар Монгол Улс эдийн засгийн хувьд бүрэн хараат болж болзошгүй гэдэг асуудлыг дийлэнх залуучууд онцолж байна. Түүнчлэн гаднын соёл, шашны нөлөө хамгийн их аюул учруулж болзошгүй гэж үзэж байгаа юм. Ойрын арван жилийн хугацаанд ч энэ нөхцөл байдал хэвээр үргэлжлэхийн зэрэгцээ гаднын кибер довтолгоо, цаашилбал цэргийн хүчээр эзлэн түрэмгийлэх ажиллагаанд өртөж болзошгүй гэдэг асуудлыг хөндөж байна. Монгол Улс ОХУ-аас зээл тусламж авбал аюулгүй байдлын хувьд зүйтэй гэж үзэх хандлагатай байна.
- Монгол Улс гадаад бодлогын хүрээнд эдийн засгийг төрөлжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг татах, хилийн чанадад амьдарч буй иргэдийнхээ эрх ашгийг хангах асуудалд анхаарал хандуулахыг залуучууд хүсэмжилж байна.
- Шанхайн хамтын ажиллагааны байгууллагыг судалгаанд оролцсон залуучуудын 41.5 хувь нь мэднэ гэж хариулсан бол 58.5 хувь нь мэдэхгүй гэж хариулжээ. Тус байгууллагад Монгол Улс гишүүнээр элсэх асуудлаар 50 орчим хувь нь мэдэхгүй гэсэн хариултыг сонгосон байна. Харин 27 хувь нь гишүүнээр элсэх ёстой гэж үзэж

байгаа бол 23 хувь нь элсэх шаардлагагүй гэж үзэж байна. • Монгол Улс энхийг сахиулах ажиллагаа дахь оролцоогоо нэмэгдүүлэх хэрэгтэй гэж залуучуудын 80 орчим хувь нь үзэж байна. Энэ хувь хэмжээ өмнөх судалгааны дүнгээс 3 орчим хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

- Байгаль нуурт цутгадаг Эгийн голын усан цахилгаан станц барих асуудлыг ОХУ-аас эсэргүүцдэг гэсэн байр суурьтай 32 хувь нь санал нийлнэ гэж хариулсан бөгөөд энэ дүн өмнөх судалгааны дүнгээс 2.4 хувиар өссөн байна. Энэ байр суурьтай санал нийлнэ, нийлэхгүй, мэдэхгүй гэсэн хариултауд эн тэнцүү байх бөгөөд гурав хуваагдсан байдалтай байна.
- Монгол Улс цаашид үндэсний уламжлалт ёс заншил, онгон дагшин байгаль, нүүдлийн соёл иргэншилд суурилсан аялал жуулчлалын бодлогыг хэрэгжүүлэх нь эдийн засагт томоохон хөрөнгө оруулалт болохын зэрэгцээ олон улсын тавцанд эх орноо эергээр сурталчлан таниулах боломж гэдгийг залуучууд онцолж байна. Залуучуудын 80 орчим хувь нь гадаадын жуулчдыг эерэг талаас нь харж байна.

Зөөлөн хүчний бодлогын үр нөлөө

- Үндэсний ижилсэл, оюун санааны дархлаанд тодорхой өөрчлөлт орж байгаа нь энэ удаагийн судалгааны дүнгээс харагдаж байна. Залуучуудын дийлэнх нь эх орноосоо явах хүсэлтэй байгааг илэрхийлэхийн зэрэгцээ гаднын дуу хөгжим, кино, соёл урлагийн бүтээлийг шимтэн сонирхож, гадаад хоол, хувцас гэх мэт амьдралын өдөр тутмын хэв маягийг даган дуурайх үзэгдэл ажиглагдаж байна.
- Англи-Америк эсвэл Хятад, Солонгос соёлын нөлөөнд автаж буй байдалтай. Америкийг эс тооцвол залуучуудын дийлэнх нь солонгос хэл сурч, солонгос кино үзэж, солонгос хоолонд дурлаж, боломж олдвол Солонгос улс руу аялах, ажиллах, амьдрах “Солонгос мөрөөдөл” бий болжээ.
- Шашин шүтлэгийн тухайд дийлэнх нь буддын шашинтай гэх боловч цагаан сар гэх мэт үндэсний уламжлалт баяраар жилдээ

ганц нэг удаа засал хийлгэх төдий сүм хийдэд очдог. Шашныхаа үндсэн судар, номлол, сургаалыг төдийлөн сайн мэддэггүй, гүн гүнзгий шүтдэггүй, бөө мөргөл, буддын шашин хоёрыг хольж хутган ойлгодог байдал судалгааны мэдээлэл цуглуулах явцад ажиглагдаж байв. Харин христийн болон мусульман шашин шүтдэг залуучууд тухайн шашныхаа онцлогоос шалтгаалж долоо хоног тутам сүмийнхээ цуглаанд очих, эсвэл өдөр бүр залбирал үйлдэх зэрэг харилцан адилгүй байна.


Судалгааны хүн ам зүйн үзүүлэлт

Судалгаанд оролцогчдын 58 хувь нь Улаанбаатар, 25 хувь нь Орхон аймаг (Эрдэнэт хот), 8 хувь нь Төв аймаг, 9 хувь нь

Булган аймгаас тус тус оролцсон бөгөөд нийт оролцогчдын 53 хувь нь эмэгтэй, 47 хувь нь эрэгтэй байна (График 41-42).


Байршил

График 41



Хүйс

График 42




Судалгаанд оролцогчдын насны бүтэц ойролцоо гарсан бөгөөд 96.7 хувь нь 18-35 хүртэлх насны 3 хувь нь 36-41 насны иргэд байна (График 43).

Ажил эрхлэлтээр нь үзвэл 15 хувь нь хувийн хэвшилд, 11 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 26 хувь нь төрийн байгууллагад ажилладаг, 36 хувь нь оюутан, 8 хувь нь ажилгүй, 2 хувь нь малчин залуучууд байна (График 44).

Нас

График 43



Ажил эрхлэлт

График 44



Монголын залуучууд ба дэлхий дахин 2024 он

Энэхүү судалгааг 18-35 хүртэлх насны залуусын МУ-ын гадаад бодлого, ОУ-ын харилцаа, бусад улс орны талаарх байр суурь, ойлголтыг тодруулах зорилгоор Монголын бодлогын инновацийн хүрээлэн ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн дэмжлэгтэйгээр 2024 оны 10-р сард хийж гүйцэтгэлээ. Монгол залуучууд гадаад ертөнцийн талаарх мэдээллийг хаанаас, хэрхэн хүлээн авч, гадаад улс орнуудын хэл, соёлыг хэрхэн үнэлж, эрэмбэлдгийг судалсан уг судалгаа нь ирээдүйн судлаачид, бодлого боловсруулагчдад өндөр ач холбогдолтой юм.